

□  
**АРХАНГАЙ АЙМАГ ӨГИЙНУУР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН**

**ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 2 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 11

Зэгстэй

**ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ  
ТОГТООХ ТУХАЙ**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 заалт, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 192, А/234 дүгээр тушаалыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит дөрөвдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

- 1.Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөх Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоож хавсралтаар баталсугай.
- 2.Хураамжаас орох орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлж, тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга /Ш.Үүрцайх/-д үүрэг болгосугай.
- 3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 10 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
- 4.Уг тогтоолыг Хууль зүй дотоод хэргийн яаманд бүртгүүлэхийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга /Б.Батчимэг/-д даалгасугай.

Дарга А.Баянмөнх